

# SBS - ийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЁС ЗҮЙН тухай

SBS нь телевиз, радио, болон дижитал хэлбэрээр хэвлэл мэдээллийн үйлчилгээг улс даяар үзүүлдэг олон нийтийн бие даасан байгууллага бөгөөд Австралийн олон нийтийн өмнө манай байгууллагын хүлээсэн үүрэг хариуцлагыг манай **байгууллагын Үндсэн Дүрэмд** тусгаж өгсөн байдаг. Австралийн засгийн газрын санхүүжилт, зар сурталчилгаа зэрэг арилжааны орлогоос манай байгууллага санхүүжигддэг.

Бид өөрсдийн сувгаараа дамжуулан Австралийн өвөрмөц түүх, орон нутгийн болон олон улсын мэдээ, цаг үеийн мэдээ, спорт, олон улсын кино болон баримтат кино, хоол, төрөл бүрийн кино болон орон нутгийн радио нэвтрүүлгийн үйлчилгээ зэргийг 60 гаруй хэлээр үзэгчиддээ хүргэдэг. Мөн түүнчлэн бид Уугуул иргэдийн түүхийг хуваалцдаг Уугуул иргэдийн үндэсний телевиз (NITV)-тэй ба үүгээрээ төрөл бүрийн контентуудыг уугуул иргэдийн нүдээр бэлтгэн хүргэдэг.

Австралийн олон нийтийн хүлээлтэд нийцсэн мэдээлэл хүргэхийн тулд SBS нь өөрийн Үйл ажиллагааны Ёс зүйг баримтладаг ба энэхүү Ёс зүй нь үзэгчид нэвтрүүлгийг телевиз, радио, онлайн эсвэл олон нийтийн сүлжээ зэрэг мэдээллийн аль сувгаар хүлээн авч байгаагаас үл хамааран манай контентууд нь манай дүрэм журам, стандартад нийцэж байхыг тодорхойлж байдаг.

**SBS-ийн үйл ажиллагааны ёс зүй нь доор дурдсан чухал асуудлуудыг багтаан тодотгосон байдаг.**



## ИТГЭЛ ХҮЛЭЭХ БАЙДАЛ

Хөндөж буй асуудалдаа хамааралтай, найдвартай контентуудыг бид хэрхэн бэлтгэдэг вэ?

- Бид бэлтгэж буй контентынхаа талаар бие даасан шийдвэр гаргадаг.
- Манай цаг үеийн мэдээ мэдээллүүд үнэн зөв, тэнцвэртэй, шударга байж нийтийн ашиг сонирхолд нийцдэг.
- Бид өргөн цар хүрээтэй үзэл бодол болон санааг багтаадаг; манай контентын агуулга шинэлэг, ур чадвар сорьсон байхаас гадна маргахуйц, асуудал дэвшүүлсэн шинж чанартай агуулгатай байдаг.



## ИЛ ТОД БАЙДАЛ

Өөрийн үзэж сонсох контентоо зөв зохистой сонгоход тань бид хэрхэн чиглүүлж туслах вэ?

- Бид танд болон таны асрамжид байгаа хүүхэд, залуучуудад тохирсон агуулгыг сонгоход тань туслах мэдээллээр бид таныг хангана.
- Манай зар сурталчилгаа нь агуулгаасаа ялгаатай байхыг бид баталгаажуулж, зарим төрлийн сурталчилгааг хаана хэрхэн байршуулах талаарх тогтоосон дүрэм журмыг баримталдаг.
- Сэтгэл эмзэглүүлж болзошгүй нэвтрүүлгийн хувьд бид үзэгчдийг бодолцон үзэж, шаардлагатай бол энэ талаар анхааруулахаас гадна, тухайн материалыг нэвтрүүлгийн агуулгаас зайлшгүй хамааралтай тохиолдолд л үзэгчдэд харуулдаг.



## ХҮНДЛЭЛ

Бид хэрхэн хүндлэлтэйгээр хандаж хүндлэлийг дэмжин хөхүүлдэг вэ?




- Бид контентын агуулгад чухал ач холбогдол өгдөг ба ялгаварлан гадуурхалт, ерөөсгөл ойлголт болон хэвшмэл ойлголтуудыг буруугаар сурталчилсан контентуудыг гаргахаас бид зайлсхийдэг.
- Бид англи хэлнээс гадна бусад хэл дээр ч контент бэлтгэн нэвтрүүлдэг ба олон ургалч үзэл бодлыг гарган илэрхийлэхийг дэмждэг.
- Бид уугуул иргэдийн асуудлыг хөндсөн контентыг танилцуулахдаа болгоомжтой ханддаг бөгөөд Абориген болон Торресын хоолойн арлын оршин суугчдын соёлын протоколд хүндэтгэлтэйгээр ханддаг.
- Бид хувь хүний нууцлалд хүндэтгэлтэй ханддаг бөгөөд мөн мэдээлэх үүргээ ч тэнцвэртэйгээр биелүүлдэг.



## ХАРИУЦЛАГА

Бид хэрхэн хариуцлага хүлээдэг вэ?

- Магтаан сайшаасан, эсвэл шүүмжилсэн эсэхээс үл хамааран манай контент болон үйлчилгээний талаарх санал бодлоо илэрхийлэх боломж, арга замуудыг бид үйлчлүүлэгчиддээ олгодог.
- SBS -ийн Үйл ажиллагааны ёс зүйн дагуу бид санал гомдол хүлээн авч барагдуулах бие даасан журамтай ба үүнийг SBS Ombudsman хэрэгжүүлдэг.



Нэмэлт мэдээллийг доорх цахим эх сурвалжаас авна уу  
[sbs.com.au/aboutus/sbs-code-of-practice](https://sbs.com.au/aboutus/sbs-code-of-practice)